



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 2/75 / ГАЗ - БНАТАГ - /2018/01-18 Монгол

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аймгийн Засаг даргын ажлын хэрэгцээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 180.0 сая төгрөгийн Land Cruiser 200 автомашины гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Автомашины гэрчилгээг аймгийн ЗДТГ-ын нэр дээр шилжүүлж зөрчлийг арилгах.

2518111

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Аймгийн ЗДТГ-ын дарга Ц.Дашцэрэн, нягтлан бодогч Т.Энхдалай нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН

ДАРГА
НЯГТЛАН БОДОГЧ

Ц.ДАШЦЭРЭН
Т.ЭНХДАЛАЙ

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 176/ГАГ/БНАТАГ-2018/01-ГА

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Баянлиг суманд “Гэртэй монгол цагаан будаа” тариалах төслийг хэрэгжүүлэхээр “Жимекс” ХХК нь 95.0 сая төгрөгийн төсөл авсан боловч аудитаар үйл ажиллагааг газар дээр нь шалгахад 2017 онд хийсэн ажлыг үнэлэх боломжгүй зөрчил илэрлээ.


Энэ нь Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2018 оны 19 тоот тогтоолоор батлагдсан Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх төсөл, төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх журмын 7.2-д заасан “Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн санхүүжилтээ авснаас хойш хуанлийн 60 хоногийн дотор үйл ажиллагааг эхлүүлсэн байх ёстой” гэсэн заалтыг зөрчсөн байна.


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.5-д заасан “Байгуулсан гэрээ, хэлцэл мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

2518113




1. Төсөлд заасан үйл ажиллагааг үе шатаар нь тодорхой үнэлэх боломжтойгоор хуваарийг дахин хийх, 2017 оны ажлыг үнэлж гүйцэтгэлийг хянаж ирүүлэх.


2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци”-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.


АЛБАН ШААРДЛАГЫГ
ӨГСӨН¹: 

АХЛАХ АУДИТОР  Б.ДОЛЖМАА
АУДИТОР Б.АЗБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

АЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА  С.БАЙГАЛМАА
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  С.БАТЦЭРЭН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Р.НАРАНЦЭЦЭГ





¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 3/77/ТАГ-БНАТАГ-(2018)-01-17 Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Үүнд:

Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн багийн эмч нарын ажлын хэрэгцээнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10 суманд 18 мотоцикл олгосон бөгөөд үүнээс Баянговь сумын багт хуваарилсан 4 мотоциклоос бусад 29,1 сая төгрөгийн 14 мотоциклийн гэрчилгээг байгууллагын нэр дээр гаргуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дугаар зүйлийн 4.1.1 дэх “Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 29,100,000 /Хорин есөн сая нэг зуун мянган/ төгрөгийн 14 ширхэг мотоциклийн гэрчилгээг гаргуулж, эзэмшигчийг төсвийн байгууллагын нэр дээр шилжүүлж зөрчлийг арилгах


2518115

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.06.10-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга А.Ганболд, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

АХЛАХ АУДИТОР АУДИТОР		Б.ДОЛЖМАА Б.АЗБАЯР
--------------------------	---	-----------------------

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН

ДАРГА НЯГТЛАН БОДОГЧ МЭРГЭЖИЛТЭН		А.ГАНБОЛД П.ОЮУНТУНГАЛАГ Д.БАЯРАА
--	--	---

¹. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 4/18-ТӨГ-ШААРАГ-2018/01-АА Номгон

Зөрчил арилгуулах тухай

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд “Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2017 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

“Баялаг номгон” ХХК-ийн сав баглаа боодол үйлдвэрлэх зориулалтаар авсан 70,0 сая төгрөгөөс хэвлэлийн машин, лазер зүсэгч машин, горив гаргагч төхөөрөмж зэргийг 60,5 сая төгрөгөөр авсан гэх боловч түүнийг баримтаар нотлоогүй, 2017 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагааг тасралтгүй явуулахаар гэрээнд заасан байхад Ажилсаг төвийн 1 өрөө байранд эдгээр тоног төхөөрөмжийг байршуулсан боловч үйл ажиллагааг эхлээгүй байна.

Энэ нь “Баялаг номгон” ХХК-ийн “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Мөнхбаттай байгуулсан ХОЗГ-2017/13/01 тоот гэрээний 3.1.2-т заасан “Хавсралт 2-д заасан цаг хугацааны графикт заасан хугацаанд төслөө хэрэгжүүлээгүй нь нэг талын санаачлагаар гэрээг цуцлах үндэслэл болно”, 5.2.1-т заасан “зээлдэгч нь санхүүжилтээ авснаас хойш Хавсралт 2-д заасан цаг хугацаанд төслөө хэрэгжүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь “Байгуулсан гэрээ, хэлцэл, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын шаардлага, нөхцлийг хангаагүй”, 4.1.7 дахь “Хууль тогтоомж зөрчсөн

2518117

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдалд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. 2018 оны 06 дугаар сарын 30-ны дотор төсөлд заасан үйл ажиллагааг эхлүүлэх

2. Албан шаардлагын биелэлтийг 2018.07.05-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга С.Байгалмаа, “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Батцэрэн, ахлах мэргэжилтэн Р.Наранцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Б.ДОЛЖМАА
Б.АЗБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН

ДАРГА

С.БАЙГАЛМАА


**“БАЯНХОНГОР ҮЙЛДВЭРЖИЛТ ХӨГЖЛИЙН
КОРПОРАЦИ” ХХК-ИЙН**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

С.БАТЦЭРЭН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Р.НАРАНЦЭЦЭГ



1. Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.